

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН АЛБАН БУС-НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН 2022  
ОНЫ АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

2022 оны 11 дүгээр сарын 22

Улаанбаатар хот

Байгууллага 2020-2023 оны ажилчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөртэй. Хөтөлбөрт заагдсан үйл ажиллагааг жил жилээр төлөвлөгөө гарган хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг.

Энэ төлөвлөгөө нь 4 зорилт, 16 үйл ажиллагааны хүрээнд төлөвлөгдсөн болно.

**Зорилт 1:** Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх

1.1. Ажилчдын цалин хөлс, үр дүнгийн мөнгөн урамшуулал, ур чадвар, илүү цагийн мөнгийг цаг тухайд нь олгож байсан.

Олговол зохих цалин: 296.422.128 үүнээс дараах байдлаар олгогдож байна.

Цалин – 183.232.195

Улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд – 14.810.160

Бусад нэмэгдэл - 24.827.260

Ур чадварт – 24.212.560

Зэргийн нэмэгдэл – 2.099.645 мянган төгрөгийг тус тус 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар олгосон байна.

1.2. Албан хаагчдад хуулийн хүрээнд хоол, унааны мөнгө олгож байна. 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 20.240.308 мянган төгрөг зарцуулсан.

1.3. Ажилдаа амжилт гаргасан ажилчдыг салбарын болон төрийн дээд шагналд тодорхойлох

- 2022 онд багш Т.Нямтулга, Г.Түвшинжаргал, Ц.Дуламсүрэн нарыг Дүүргийн ИТХ-ын шагналаар шагнаж урамшуулав.

**Зорилт 2:** Албан хаагчдын албан байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх

2.1. Багш, ажилчдаас хэрэгцээний болон сэтгэл ханамжийн судалгаа авч ажлын байрны таатай орчинг бүрдүүлэх

Багш, ажилчдаас хэрэгцээний судалгаа авсаны үндсэн дээр коридорт:

- байгууллагын үйл ажиллагааг сар бүр сурталчлах самбар
- мэдээллийн самбар
- тогтвортой хөгжлийн боловсролын 17 зорилго
- анги танхим, өрөөний хаягийг хос бичгээр хийлээ.

2.2. Багш, ажилчдыг амралтын цагаараа ая тухтай амрах, ажлын алжаалаа тайлах амралтын өрөөг тохижуулах

Багш ажилчдын амралтын өрөө болон Тусгай хэрэгцээт хэрэгцээт боловсролын өрөөний тохижилт 1.500.000, хэрэглэгдэхүүн -500.000 мянган төгрөгөөр тохижуулав.

2.3. Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай бичгийн хэрэгслээр хангах

2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар бичиг хэргийн зардалд 1.136.000, хичээл үйлдвэрлэл, сургалтын зардалд 2.559.700 төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.4. Албан хаагчдыг сүүлийн үеийн шаардлагад нийцэхүйц компьютер, техник хэрэгслээр хангах асуудлыг үе шаттай шийдвэрлэх

2021 онд санхүүжилтээр 3 notebook, цахим хичээл бичих багц хэрэгсэл, өсгөгчийг 7.532.000 мянган төгрөгөөр авч 2022 оны 01 дүгээр сард багш Г.Түвшинжаргал, Г.Саруул, Ц.Дуламсүрэн нарыг хангасан.

## 2.5. Интернет болон дотоод сүлжээний байнгын тасралтгүй ажиллагааг хангах

2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар шуудан холбоо, интернэтийн төлбөрт 2.150.000 мянган төгрөг зарцуулсан.

### **Зорилт 3.** Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэл

3.1 Гэр хороололд амьдардаг ажилчдад түлээ нүүрсний мөнгө олгох

- Одоогоор шийдвэрлэх боломжгүй байна.

3.2 Сурч боловсроход нь дэмжлэг үзүүлж цалинтай чөлөө олгох

- Багш С.Энхзаяа магистарт, О.Лхагвасүрэн бакалаврт суралцахад дэмжлэг үзүүлж, 1 сарын хугацаатай цалинтай чөлөө өгч ажиллалаа.

3.3. Нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан албан хаагчдад төсөвт багтаан мөнгөн тусламж олгох

- Одоогоор шийдвэрлэх боломжгүй байна.

### **Зорилт 4:** Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх

4.1. Багш ажилчдыг бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд бүрэн хамруулах

- 2022 оны 5 дугаар сард багш, ажилчдыг ХУД-ийн Биеийн тамир, Спорт хороотой хамтран бие бялдрын хөгжлийн сорилд бүх ажилчдаа хамруулж, мэргэжлийн зөвлөгөө авахуулсан.

4.2. Ажлын байран дээр дасгал хөдөлгөөн хийх

- Байгууллагын спорт хамтлагийнхан өглөө бүр 8:20-8:30 цагт өглөөний дасгал хийж хэвшсэн. "Илүүдэл жингүй -Эртэч Монгол" хөтөлбөрт байгууллагаар хамрагдсан.

4.5. Албан хаагчдын эрүүл мэндийг хангах зорилгоор "Явган алхалт"-ыг зохион байгуулах

- Дүүргээс зохион байгуулсан алхалтаас гадна байгууллагын спортын багаас зохион байгуулсан алхалтад хамт олноороо 3 удаа оролцож эрүүл мэндээ дэмжин ажиллалаа.

4.6 Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил хамруулах

- 2022 оны 9 дүгээр сард нийт багш, ажилтан 15 хүнийг эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа.

ТАЙЛАН БИЧСЭН:

НИЙГМИЙН АЖИЛТАН  О.МЯГМАРСҮРЭН

ХЯНАСАН:

ЗАХИРАЛ 

Т.РЭГЗЭДМАА

